*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХАРЬЯ БАЙГУУЛЛАГЫН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН МЯНГАНБАЯРЫН МӨНХТУУЛЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилт 1. НЭГ. “САЛБАРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ, ЗӨВЛӨМЖ ГАРГАХ ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД. | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Төрийн нарийн бичгийн даргын А ангилалд хамаарах төсөв санхүүтэй холбогдон гарсан тушаалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргасан байна. | ХШҮХ танилцуулгын тоо | - | 1 | Төрийн нарийн бичгийн даргын А ангилалд хамаарах нийт 189 тушаалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг 2024 оны 2 дугаар улирлын байдлаар хийж, дүгнэлт, зөвлөмжийг Төрийн нарийн бичгийн даргад танилцуулсан. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилт 74.8 хувь буюу “хэрэгжих шатанд” гэсэн үнэлгээтэй дүгнэгдсэн. Төрийн нарийн бичгийн даргын А тушаалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн танилцуулга, зөвлөмжийг яамны газар хэлтсүүдэд танилцуулж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийг өгч ажилласан. | 2024.05.31-2024.06.15 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | Арга хэмжээ 1.2. Байгууллагад ирсэн хөндлөнгийн хяналтын зөвлөмжийн гүйцэтгэл, хэрэгжилтийг хянах, зөвлөмж гаргах. | Гарсан дүгнэлт зөвлөмжийг хүргүүлсэн албан бичгийн тоо | - | 1 | Үндэсний аудитын газраас “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан”-д хийсэн аудит, Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Цахим хөгжил харилцаа холбооны сайдаар батлуулан 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 01/786, 01/787 дугаартай албан бичгүүдээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. Дээрх төлөвлөгөөний төсөлд харьяа, салбарын байгууллагаас 2024 оны 03 дугаар сарын 20-ны 03/549, 03 дугаар сарын 28-ны өдрийн 03/624 дугаартай албан бичгээр саналыг нэгтгэн авсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах талаар зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 01/1119 дугаартай албан бичгээр зөвлөмж хүргүүлсэн. Мөн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 01/234 тоот албан бичгээр ҮАГ-т хүргүүлсэн. | 2024.01.02-12.31 | 70% |
| Зорилт 2. ХОЁР: “ДОТООД ХЯНАЛТЫН ҮЙЛ ЯВЦЫН ҮР НӨЛӨӨТЭЙ БА ҮР АШИГТАЙ БАЙДЛЫГ ҮНЭЛЭН БАЙНГЫН САЙЖРУУЛАЛТЫГ САНАЛ БОЛГОХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД. | | | | | | | |
| 3 | Арга хэмжээ 2.1. Байгууллагын 2023 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, холбогдох байгууллагад хүргүүлэх. | ХШҮХ танилцуулгын тоо | 2023 онд ЗГХЭГ-т 1 бичиг хүргүүлсэн. | 1 | Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний стратеги төлөвлөгөөний 2023 оны биелэлтэд 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрөөр хяналт шинжилгээ, хийхэд 90.1 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэгдсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр гарсан дүгнэлт, зөвлөмжийг газрын 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 01 дугаартай дотоод бичгээр яамны газар хэлтсийн нэгжүүдэд хүргүүлсэн. Мөн байгууллагын файлын санд хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга, зөвлөмжийг оруулж, бүх албан хаагчдад ERP системээс орж танилцах, боломжийг бүрдүүлсэн. Стратеги төлөвлөгөөний биелэлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг Монгол Улсын Засгийн газрын Хяналт | 2024.04.01-05.01 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрэгжүүлэх газарт 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/439 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | | |
| 4 | Арга хэмжээ 2.2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, холбогдох байгууллагад хүргүүлэх. | Гарсан тайланг ЗГХЭГ-т хүргүүлсэн баримт бичгийн тоо | 2023 онд ЗГХЭГ-т 1 бичиг хүргүүлсэн. | 1 | Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн 2023 оны биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны удирдлагын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн хамт 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 03/425 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд хуулийн хугацаанд тайлагнасан. Мөн Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн 2024 оны эхний хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийсэн тайланг ЗГХЭГ-т 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 03/822 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 2024.02.25-03.01 | 100% |
| **ГУРАВ: “САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ, ЗӨВЛӨМЖ ГАРГАХАД ХЯНАЛТ ТАВИХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД.** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Арга хэмжээ 3.1. Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа болон салбар байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх. | Байгууллагын тоо | 3 | 2 | Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллага болох “Үндэсний Дата төв” УТҮГ болон “РТҮС” УТҮГ-дын 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийж Төрийн нарийн бичгийн даргад танилцуулсан. “Үндэсний Дата төв” УТҮГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн танилцуулгыг 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 03/879 дугаар албан бичгээр, “РТҮС” УТҮГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн танилцуулгыг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны 03/778 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн. Мөн ЦХХХ-ны Сайдын 2024 оны А/56 дугаар тушаалаар Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газарт “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх удирдамж батлах тухай” тушаал гарч тус хяналт, шалтгалтыг 2024 оны 06 дугаар сарын 10-18-ний өдрүүдэд зохион байгуулан явуулсан. Хяналт шалгалтын танилцуулга, зөвлөмжийг 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 03/1356 дугаар албан бичгээр хүргүүлсэн. ЦХИХХ-ны Сайдын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар харьяа болон төрийн өмчит газруудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, ажлын хэсэг байгуулсан тушаал гарч, харьяа 3 байгууллагаас холбогдох материалуудыг татан авч, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг эхлүүлээд байна. | 2024.01.02-12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Арга хэмжээ 3.2. Аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах. /(Нийслэл, 21 аймаг) | ЗГХЭГ-т хүргүүлсэн албан бичгийн тоо, Дүгнэлт, зөвлөмжийг танилцуулсан аймгийн тоо | 2023 онд 22 гэрээний хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж ЗГХЭГ-т хүргүүлсэн. Мөн аймаг, Нийслэлийн | 22 | Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 21 аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлтэд 2023 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд "Тодорхой үр дүнд хүрсэн" буюу 91.5 хувьтай дүгнэгдсэн. Сайдтай байгуулсан гэрээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 01/531 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Засгийн Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр бүрэн тайлагнасан. Мөн 21 аймгийн Засаг дарга болон нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид гэрээ дүгнэсэн тайлан, дүгнэлт зөвлөмжийг 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 01/629 дүгээр албан бичгээр тус тус хүргүүлсэн. | 2024.02.01-2024.04.01 | 100% |
| **ДӨРӨВ: "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД.** | | | | | | | |
| 7. | Арга хэмжээ 4.1 Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журамд заасан хугацаанд боловсруулж батлуулах, тайлагнах. | Хэрэгжилтийн хувь | - | 100% | Гүйцэтгэлийн төлөвлөгөө болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг хуулийн хугацаанд батлуулж, тайлагнасан. | 2024.01,02-2024.01.15 | 100% |
| 8. | Арга хэмжээ 4.2 Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэх. | Хэрэгжилтийн хувь | - | 100% | 2024 онд Төрийн байгууллагаас ирсэн нийт 46 албан бичгийн хариуг чиг үүргийн дагуу хуулийн хугацаанд хариуг явуулсан бөгөөд нийт ирсэн бичгийн 38 бичигт хариуг хуулийн хугацаанд нь хүргүүлсэн байна. | 2024.01.02-12.31 | 100% |
| 9. | Арга хэмжээ 4.3. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг | Хэрэгжилтийн хувь | - | 100% | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу | 2024.02.01-2024.02.15 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | | | | Хөрөнгө оруулалтын мэдүүлгийг хуулийн хугацаанд тайлагнасан. | | |
| 10. | Арга хэмжээ 4.4. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг заасан хугацаанд нь, чанартай гүйцэтгэх, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх. | Хэрэгжилтийн хувь | - | 100% | Нэгжийн даргаас өгсөн үүргийн дагуу Газрын шуурхай хурлын 11 удаагийн тэмдэглэлийг хөтөлж биелэлтийг гарган, нэгжийн даргаар хянан баталгаажуулсан. Мөн газрын 7 хоногийн тайланг 11, сарын тайланг 5 удаа нэгтгэн гаргаж нэгжийн даргаар хянан баталгаажуулж, ТЗУГ-т тайлагнасан. Газрын даргын үүрэг болгосны дагуу Хяналт, хэрэгжүүлэх газраас ирсэн салбарын хяналтын нарийвчилсан судалгааг 21 аймгаас авч нэгтгэн маягтын дагуу тайлагнаж 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 01/533 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Хяналт, үнэлгээний үндэсний хорооноос ирүүлсэн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан судалгааг гаргаж ЦХИХХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 03/485 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Мөн Хяналт, үнэлгээний үндэсний хорооноос ирүүлсэн “Захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих” салбарын журмын төсөлд санал өгч тус тус ажилласан. Яамны 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд орсон ажлуудын гэрээ дүгнэсэн актад 2024 оны 04 дүгээр сараас эхлэн нийт 56 гэрээ дүгнэсэн актад Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/01 дүгээр тушаалаар баталсан журмын хэрэгжилтэд хяналт, тавин ажилласан. | 2024.01.02-2024.12.31 | 100% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 1. Удирдлагын Академийн “Төрийн албан хаагчийн богино, дунд хугацааны сургалтын хөтөлбөр”-т хамрагдах. | Сургалтад хамрагдаж сертифик | - | 1 | Удирдлагын Академийн Ахлах түшмэлийн сургалтад амжилттай суралцан төгсөж, 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр сертификат авсан. | 2024.01.02-2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | ат авсан байна | | | | | |
| 2. | Арга хэмжээ 2. Байгууллагаас болон бусад газраас зохион байгуулсан сургалтад хамрагдах. | Сургалтад хамрагдсан байна. | - | 3 | 2024 оны жилийн эцсийн байдлаар яамнаас зохион байгуулсан нийт 18 удаагийн сургалтад хамрагдсан. Үүнд: Засгийн газрын хэрэг эрхлэх газраас БНСУ-ын төрийн академитай хамтран 2024 оны 03 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан сургалт, Сангийн яамнаас зохион байгуулсан “Төсөл хөтөлбөр болон гадны зээл тусламжаар хэрэгжиж буй хөтөлбөрийн тайлан гаргахтай” холбоотой сургалт, “Төрийн албан хаагчийн сургалт нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн сургалт, Засгийн газрын Хяналт, хэрэгжүүлэх газраас зохион байгуулсан “Өглөөний уулзалт” сургалт, Сангийн яамнаас зохион байгуулсан төсөл хөтөлбөрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх сургалт, Төрийн албаны зөвлөлөөс долоо хоног болгоны пүрэв гаригт зохион байгуулагддаг “7:4:10” сэдэвт сургалтуудад тухай бүр хамрагдсан. Мөн Яамнаас зохион байгуулсан Critical thinking буюу эргэцүүлэх сэтгэлгээний арга барил, асуудалд бодитой хандах, чадварыг хөгжүүлэх сургалт, “Нийгмийн сүлжээн дэх эрх зүйн зохицуулалт”, “Хэвлэлийн өөрийн зохицуулалтын туршлага” судлах сургалтуудад тус тус хамрагдсан. | 2024.01.02-2024.12.31 | 100% |
| Нийт | | | | | | | 97% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**
ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХАРЬЯ БАЙГУУЛЛАГЫН ТӨСӨЛ
ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ............................................ / М.МӨНХТУУЛ/ 2024. 12. 05
*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*